

## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ГАДААД ХАРИЛЦААНЫ 2013 ОНЫ ТАЙЛАН

Тайлангийн хугацаанд зохион байгуулагдсан гадаад харилцааны арга хэмжээнүүдийг жагсаавал:


1. ИТХ-ын урьдны найрамдалт харилцаат Япон улсын Нийгата мужийн Госен хот, Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл хотын Сонгбук дүүрэг, ОХУ-ын Иркутск муж, БНХАУ-ын Тяньжин хотын Хөпин дүүрэг, ӨМӨЗО-ны Сайхан дүүрэгтэй харилцаагаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинээр 12 элчин сайдын яамд, төлөөлөгчийн газруудад хамтран ажиллах тухай хүсэлт гаргаж, 5 элчин сайдын яам, төлөөлөгчийн газраас эерэг хариу авч, хамтран ажиллахаар боллоо.
2. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай харилцаа холбоотой ажилладаг гадаадын байгууллага, иргэд тухайлбал, Япон Монголын найрамдлын нийгэмлэг, Япон, БНСУ, БНХАУ-ын элчин сайдын яамд, ЖАЙКА, КОЙКА-гийн суурин төлөөлөгчийн газар, Мянганы сорилын сан, Английн VSO олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газар, Улаан загалмайн нийгэмлэг, Хүүхдийг ивээх сангийн хүүхэд хамгааллын хөтөлбөр, Кристина Нобелийн Хүүхдийн сан зэрэг байгууллагуудын төлөөллийг урьж оролцуулан дүүргийн 20 жилийн ойн медалиар шагнаж алдаршуулах ажлыг зохион байгууллаа.





4. Япон улсын Нийгата мужийн Госен хотын даргад хандан санал тавьснаар Чингэлтэй дүүргийн ИТХ-ын дарга Д.Бат-Эрдэнэ болон төлөөлөгчдийг Госен хотод айлчлах урилга явуулж, урилгын дагуу албан айлчлалыг амжилттай зохион байгууллаа. Айлчлалын бүрэлдэхүүнд Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ, тэргүүлэгч Ж.Лхагвасүрэн, төлөөлөгч Д.Алтанхуяг, төлөөлөгч Ү.Тэгшбаатар, 5-р хорооны засаг дарга С.Амарбаясгалан, 16-р хорооны засаг дарга Ш.Жаргалсайхан болон хурлын ажлын албаны ажилтан М.Туяа нар багтаж явсан бөгөөд айлчлалын үеэр Чингэлтэй дүүргийн төлөөлөгчдийг Нийгата мужийн орлогч даргахүлээн авч хүндэтгэл үзүүлж, Монгол улсын Чингэлтэй дүүрэгтэй ийнхүү найрамдалт харилцаа тогтоон ажиллаж байгаа Госен хотыг дэмжиж, цаашдаа энэхүү харилцааг хөгжүүлэхэд бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийллээ. Айлчлалын баг Нийгата мужийн Госен хотын хог боловсруулах үйлдвэр, шинээр нээгдээд удаагүй байгаа цэцэрлэг, Атаго бага сургууль, Такахаши нит хэмээх нэхмэл сүлжмэл хувцасны үйлдвэр, Үзүрахаши өндөр настны асрамжийн газар, Хокү-Эцү бетонон эдлэлийн үйлдвэр, Таймацу хүнсний үйлдвэр, Нийгата мужийн Зүүн хойд Азийн эдийн засгийн судлалын төв зэргээр зочилж, үйл ажиллагаатай нь танилцлаа.

Чингэлтэй дүүрэг, Госен хот хоорондын хамтын ажиллагааны талаар санал солилцох уулзалтыг зохион байгуулж, монгол хүүхэд солилцооны хөтөлбөрийн явц, цаашдын хэрэгжилтийн талаар санал солилцлоо. Айлчлалын үр дүнд 2013 оны хүүхэд солилцооны хөтөлбөрийг 6 сард, Нийгата мужийн танилцуулах бизнес уулзалт өдөрлөгийг 2014 оны 8 сард тус тус зохион байгуулахаар тохирлоо.





5. ОХУ-ын Халимаг улсын Их Бурла дүүргийнхэнтэй холбоо тогтоож, Халимаг улсын Эдийн засаг, худалдааны яамны байнгын зөвлөлийн гишүүн Алтман Трофимовтой уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлж, төлөвлөгөөгөө ярилцлаа.



6. 2013 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс 2013 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийг хүртэл Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч Ч.Буянжаргал, Ж.Чимэдцогзол, Төлөөлөгч Ч.Болормаа, Ц.Дуламжав, Л.Баярсайхан, Ц.Энхжаргал, Ж.Оюунцэцэг болон 2 дугаар хорооны Засаг дарга Э.Орхон, 4 дүгээр хорооны Засаг дарга С.Отгонсүрэн, 6 дугаар хорооны Засаг дарга Ц.Дунгармаа, 9 дүгээр хорооны Засаг дарга Н.Оюунцэцэг, 15 дугаар хорооны Засаг дарга Б.Цогзолмаа, 19 дүгээр хорооны Засаг дарга Д.Алимаа, Хурлын ажлын албаны ажилтан С.Туяа, Бизнес инкубатор төвийн ажилтан Б.Болор нарын бүрэлдэхүүнтэй төлөөлөгч нар БНСУ-ын Сөүл хотод “Солонгосын Шинэ тосгон хөдөлгөөн”-ий вакумжуулсан сургалтанд хамрагдлаа. Шинэ тосгоны удирдагч бэлтгэх сургалтын төв нь идэвхтэн гишүүдийн ур чадварыг сайжруулах, чадвартай удирдагчдын санаачлагаар хөдөлгөөн өрнүүлэх, “Хөдөлмөрч-Санаачлагч-Хамтач” зорилгыг биелүүлэхийн тулд суралцагсад болон хариуцагч багш, ажилчид хамтдаа байрлаж, олон нийтийн харилцаанд зөвхөн сургах, шинэ

тосгоны үзэл баримтлал, амжилттай ажилласан ажлуудын талаар хэлэлцүүлэг зохион байгуулж харилцан үзэл бодлоо солилцох, төгсөгчдөд цаашид ажлын талбар дээр заавар зөвлөлгөө өгч, дэмжиж туслах зорилготой үйл ажиллагаа явуулдаг.



7. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ, хурлын Тэргүүлэгч Ц.Ганболд, Төлөөлөгч Л.Давийчомбо, Ё.Отгонбаяр, М.Эрхэмбаяр, Ц.Отгонбаатар, дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан

Б.Агиймаа, 16-р хорооны зохион байгуулагч З.Ганбат болон хурлын ажлын албаны ажилтан Л.Батболд нарын бүрэлдэхүүнтэй айлчлалын баг Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Сонгбук дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын урилгаар 2013.05.13-ны өдрөөс 2013.05.17-ныг хүртэл албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр Сонгбук дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд айлчилж, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Шин Жэй Кюн тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж танилцан, Сонгбук дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит бус хуралдаанд оролцлоо. Мөн Сонгбук дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын байр, Сонгбук дүүргийн иргэдэд үйлчлэх төв, Сонгбук дүүргээс байгуулсан “Ариранг” кино театрт танилцсан. Тус айлчлалын үеэр Чингэлтэй дүүргийн төлөөлөгчдийг Сонгбук дүүргийн Засаг дарга Ким Ёон-бэй хүлээн авч хүндэтгэл үзүүлж, Монгол улсын Чингэлтэй дүүрэгтэй найрамдалт харилцаа тогтоон ажиллаж байгаа энэхүү харилцааг цаашдаа хөгжүүлэхэд бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийллээ. Мөн Чингэлтэй дүүрэгт тулгамдаж байгаа асуудлуудын талаар ярилцаж, цаашид хамтран ажиллах чиглэлүүдийг судлан үзэхээр тохиролцов.



8. Япон улсын Токио хотын Санкёо Акватек компанийн захирал нь 2013 оны 05 дугаар сарын 29-ний өдрөөс 06 дугаар сарын 01-нийг хүртэл, 07 дугаар сарын 15-ны өдрөөс 20-ны өдрийг хүртэл 2 удаа Чингэлтэй дүүрэгт ирж, хамтран ажиллахаар ярилцлаа. Эхний удаа ирэхдээ Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэтэй уулзаж, Санкёо Акватек компаний үйл ажиллагааны талаар танилцууллаа. Чингэлтэй дүүрэгт гэр хорооллын дундах далангаас халин гардаг, өвлийн цагт хөлдөж овоодог газрын гүний бохир усыг цэвэршүүлж, дүүргийн иргэдийн ундны усны хангамжинд нэмэр болох зорилгоор тус компаниас санаачилга гарган, Чингэлтэй дүүрэгтэй хамтран ажиллах саналыг тавьсан. Үүний дагуу эхний удаад Чингэлтэй дүүргийн 12, 16, 18 дугаар хороодын нутаг дэвсгэрт байгаа далангийн байдлыг үзэж танилцлаа. Хоёр дахь удаа ирэхдээ Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны нэг даланг сонгон авч, тэнд нарны энерги ашиглан далангаар урсаж байгаа бохир усыг цэвэршүүлэх жижиг оврын байгууламжийн зураг, төсөл, төсвийг хийж ирсэн байлаа. Тус байгууламжийн төслийн талаар ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид болон ЗДТГ-ын дарга нарт танилцуулж, ийм байгууламж барих тохиолдолд төсөв хөрөнгийг нь хэрхэн шийдвэрлэх, хоёр тал юу хариуцах талаар санал солилцлоо. Ерөнхийдөө төхөөрөмжийг Санкёо Акватек компани хариуцаж, байгууламжийн барилгын ажлыг Чингэлтэй дүүрэг хариуцахаар харилцан санал тохирсон болно. Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн зардлыг гадны хөрөнгө оруулалтаар шийдвэрлүүлэх арга замыг хамтран эрэлхийлэхээр шийдвэрлэлээ. Санкёо Акватек компани нь энэ оны 8 сард ус цэвэршүүлэх бага оврын төхөөрөмжийг японоос илгээж, одоогийн байдлаар Чингэлтэй Тохижилт үйлчилгээний компани хариуцан аваад хадгалж байгаа болно.




9. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын урилгаар БНСУ-ын Инчеон хотын Соо дүүргийн ИТХ-ын дарга И Сан Суп тэргүүтэй 6 төлөөлөгчид 2013 оны 06 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ны өдрийг дуустал Чингэлтэй дүүрэгт айлчиллаа. Айлчлалын үеэр 2 дүүргийн удирдлагууд Найрамдалт харилцааны харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурж, цаашдын ажлынхаа зорилго, чиглэлийг баталгаажууллаа. Соо дүүрэг

нь Инчеон хотын төвд байрладаг, хөдөлгөөний сүлжээ дүүрэг бөгөөд 2014 оны Азийн тоглолтыг зохион байгуулах дүүргээр шалгаран бэлтгэл ажлаа хангаж байгаа юм байна.



10. Япон улсын Нийгата мужийн Госен хотын орлогч дарга Икараши Акира тэргүүтэй төлөөлөгчид Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын урилгаар 2013 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс 2013 оны 08 дугаар сарын 22-ны өдрийг дуустал албан ёсны айлчлал хийлээ. Энэ удаагийн айлчлалын гол зорилго нь ирэх жил буюу 2014 оны намар 8 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн тохиролцоод байгаа “Чингэлтэй Нийгата Госен бизнес соёлын өдөрлөг”-ийн зохион байгуулалтын асуудлыг харилцан ярилцах, санал солилцох, тохиролцох зорилготой байлаа. Тус уулзалтанд Нийгата мужийн Тамгын газрын дарга Ютака Сакума тэргүүтэй төлөөлөгчид, Чингэлтэй дүүргийн ИТХ-ын дарга, Тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газрын дарга ажилтнууд оролцож, 2014 онд зохион байгуулагдахаар төлөвлөж байгаа “Чингэлтэй Нийгата Госен бизнес соёлын өдөрлөг”-ийг ирэх оны 8 дугаар сарын эхний 10 хоногт зохион байгуулахаар харилцан санал нийллээ. Госен хотын зүгээс соёлын өдрийг нь хариуцаж, Нийгата мужаас бизнесийн өдрийг нь хариуцаж, Нийгата мужид бизнес эрхлэгчид, тус өдөрлөгт оролцох сонирхол бүхий байгууллага, хамт олонд сурталчлах, зар түгээх ажлыг хариуцаж ажиллахаар тохирлоо. Чингэлтэй дүүргийн зүгээс дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, сургууль цэцэрлэгүүд болон соёлын байгууллага хамт олонтой хамтарч ажиллаж, тус өдөрлөгт хамруулахаа илэрхийллээ.





11. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын Сунпа дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Юн Мүү Пак тэргүүтэй 17 төлөөлөгчид 2013 оны 09 дүгээр сарын 09-ний өдрөөс 2013 оны 09 дүгээр сарын 12-ны хооронд Чингэлтэй дүүрэгт айлчиллаа. Айлчлалын үеэр ИТХ-ын дарга Д.Бат-Эрдэнэ, тэргүүлэгчид, төлөөлөгчдийн төлөөлөлтэй уулзалт хийж, хамтын ажиллагааны цаашдын чиглэлийн талаар санал солилцлоо.



12. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Д.Бат-Эрдэнэ, хурлын Төлөөлөгч С.Энхтайван, Ц.Рэнцэндорж, Л.Энхтуяа, П.Батбаяр, Б.Сарангоо дүүргийн 4 дүгээр хорооны нийгмийн ажилтан Л.Баярмаа, 8 дугаар хорооны зохион байгуулагч Н.Доржпүрэв, 16 дугаар хорооны нийгмийн ажилтан Г.Оюунцэцэг болон хурлын ажлын албаны ажилтан Г.Ундрал, хурлын гадаад харилцааны ажилтан М.Туяа нарын бүрэлдэхүүнтэй айлчлалын баг Бүгд Найрамдах Солонгос Улсын Инчеон хотын Соо дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга И Сан Супийн урилгаар 2013.10.14-ний өдрөөс 2013.10.18-ны өдрийг дуустал Соо дүүрэгт албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын баг Соо дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тамгын газар, ИТХ-ын хуралдааны танхимаар орж, хурлын зохион байгуулалтын байдалтай танилцлаа. Хог боловсруулах үйлдвэр, Инчеон хотын Смарт сити цогцолборын бүтээн байгуулалт, Азийн олимпын гол стадионы байгууламжтай танилцаж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн холбооны дарга, гишүүд, компанийн захирлуудтай уулзалт хийж, танилцаж, харилцан туршлага солилцлоо. ЧД-ийн ИТХ-ын дарга Д.Бат-Эрдэнэ Чингэлтэй дүүрэг нь шийдвэр гаргах түвшинд иргэд санал бодлоо илэрхийлэх, иргэдийн оролцоог хангах зорилгоор Иргэний танхимыг нээж ажиллуулах тал дээр тусламж дэмжлэг хүсэхэд Соо дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зүгээс дэмжиж ажиллахаа илэрхийллээ.



Тайлан бичсэн: Гадаад харилцааны ажилтан

М.Туяа